

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а”, 29.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.5, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 92 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг батлагдсантай холбогдуулан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө-2021” дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төсөл боловсруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах ажлыг холбогдох хуульд заасан хугацаанд зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг хууль журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Дэд ажлын хэсгүүдийн ахлагч нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, явц, үр дүнгийн талаар тухай бүр танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Уртнасан/-т болон Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР  
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН

### НЭГ. АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
Гишүүд:	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга; Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Бодлогын судалгааны тасгийн дарга.

### ХОЁР. ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1.Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого хариуцсан  
Дэд ажлын хэсэг

Ахлагч:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
---------	---

Гишүүд:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий мэргэжилтэн; Нийслэлийн Боловсролын газар; Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга; Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга; Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга; Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга; Нийслэлийн Нийгмийн халамжийн газар;
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн салбар хариуцсан мэргэжилтэн.

## 2.Хүний хөгжлийн бодлого хариуцсан Дэд ажлын хэсэг

Ахлагч:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
Гишүүд:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн зарлагын эдийн засагч; Нийслэлийн Боловсролын газрын дарга; Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга; Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга; Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга; Нийслэлийн Спортын хорооны дарга; Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга; Нийслэлийн Нийгмийн халамжийн газар;
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.

## 3.Эдийн засгийн бодлого хариуцсан Дэд ажлын хэсэг

Ахлагч:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч;
Гишүүд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий мэргэжилтэн; Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга; Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар; Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга; Нийслэлийн Татварын газар; Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын дарга; Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга; Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга; Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга; Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга; Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;

Улаанбаатар хотын хөгжлийн корпорацийн ХК-ийн гүйцэтгэх захирал;  
Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засгийн хөгжил, үйлдвэрлэл, инновацын бодлого, хариуцсан мэргэжилтэн.

#### 4. Ногоон хөгжлийн бодлого хариуцсан Дэд ажлын хэсэг

Ахлагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий мэргэжилтэн;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга;  
Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;  
Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга;  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;  
Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Ногоон хөгжил, агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн.

#### 5. Засаглалын бодлого хариуцсан Дэд ажлын хэсэг

Ахлагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга;

Гишүүд: Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж, эрх зүйн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий мэргэжилтэн;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн;  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга;

Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтсийн дарга;  
Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;  
Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга;  
Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга;  
Нийслэлийн Архивын газрын дарга;  
Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын дарга;  
Нийслэлийн Дотоод аудитын газрын дарга;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засаг даргын шийдвэр, захиргааны шийдвэр хариуцсан ахлах мэргэжилтэн.

#### 6. Дагуул хот, бүс, орон нутгийн хөгжил хариуцсан Дэд ажлын хэсэг

Ахлагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий мэргэжилтэн;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга;  
Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар;  
Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;  
Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга;  
Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга;  
Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга;  
Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга;  
Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн ерөнхий захирал;  
Улаанбаатар хотын хөгжлийн корпорацийн ХК-ийн гүйцэтгэх захирал;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн, Орон сууц, дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн.